МЭДЭЭ · 2021 оны 1-р сарын 29

ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ" ХҮРТЛЭЭ



Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын прокурорын газар гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэлтэй ажилласан шилдэг байгууллагаар шалгарлаа.

Тус аймгийн Засаг даргын тамгын газраас энэ оны 1 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн хууль хяналтын байгууллагуудын удирдлагуудын уулзалтыг зохион байгуулж, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг хэлэлцсэн байна.

Мөн үеэр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2020 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутагтаа манлайлж ажилласан иргэн, байгууллагуудад шагнал гардуулсан бөгөөд Хархорин сум дахь сум дундын прокурорын газрыг "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнажээ.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
САЛБАР ЗӨВЛӨЛ

№ 20/01

ХҮНДЭТ
ӨРГӨМЖЛӨЛ

Эрхэм хүндэт Харагчин сүм дахь сүм дүүгийн Прокурорын төлөө танаа

Иргэдийн аюулгүй байдал, амгалан тайван амьдрах боломжийг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэлтэй ажиллаж байгааг тань үнэлж ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ мөнгөн шагналаар шагнав.

Таны цаашдын ажилд амжилт, сайн сайхныг хүсье.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ..... О.ЛҮРЭВДОРЖ

2022 оны 12 сарын 24-ны өдөр

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2767